

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ СУМЫН

### 2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН МЭДЭЭ

#### УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

2023 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 68,330.0 мянган төгрөг төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 83,500.4 мянган төгрөг буюу 122.2 хувиар орлогыг давуулан биелүүлсэн байна.

Баянтал сумын нэгтгэлийн /ОН/ төлөвлөгөө 1,015,400.5 мянган төгрөг, гүйцэтгэл 675,226.0 мянган төгрөг байна. Үүнээс үндсэн цалин,унаа хоол,нэмэгдэл урамшуулалд 199,425.2 мянган төгрөг НДШ 25,606.1 мянган төгрөг зарцуулсан байна.

Баянтал сумын нэгтгэлийн /ОН/ өглөг 6,500.0 мянган төгрөг , авлага 3,758.5 мянган төгрөг байна. Өглөг үүссэн шалтгаан байгууллагуудын тогтмол зардал болох гэрэл цахилгааны зардал 1 сараас нэмэгдснээс үүссэн өглөг байна.

Засаг дарга , Засаг даргын Тамгын газарт ирсэн, явсан, хариутай албан бичиг, өргөдөл гомдолын шийдвэрлэлтийн талаар тайлагнахад,

- 1. Ирсэн албан бичиг -19
- -Үүнээс:
- Бүртгэл хяналтын карт хөтөлсөн хариутай албан бичиг -2
- Хугацаандаа явсан хариутай албан бичиг -2
- Хугацаа болоогүй-2
- Явуулсан албан бичиг-5
- **Захирамж, Тушаал**
- Захирамж “А”-2 гарсан
- Захирамж “Б”-2 гарсан
- **Өргөдөл, гомдолын шийдвэрлэлт**
- **1. Засаг даргад ирсэн өргөдөл-3**
- 

/шийдвэрлэх хугацаа болоогүй

07-р сарын 10-ны өдөр Баянтал сумын баяр наадам амжилттай зохион байгуулагдлаа. Баяр наадамд хүчит бөхийн барилдаан, хурдан морь шүдлэн, хязгаалан, соёолон насны ангилалаар мөн шагайн харваа, Үндэсний сурын харваан төрлүүдээр зохион байгуулагдлаа.



Хүчит бөхийн барилдаанд сумын заан, сумын начин цолтонууд төрж. Үндэсний сурын харваанд сумын гоц мэргэн, сумын мэргэн цолтонууд төрж баяр наадамд дэлгэр сайхан болж өнгөрлөө.

1-р багийн иргэдийн нийтийн хурал

ОНХС-н иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах

“Чойр хайрхан” “Ноос ноолуур боловсруулах үйлдвэр” төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол ажлын танилцуулга.

Өвөлжөө хаваржааны газар хүссэн 2 иргэний саналыг хэлэлцэх

2-р багийн иргэдийн нийтийн хурал

ОНХС-н иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах

ОНХС-н иргэдийн авсан саналыг эрэмбэлэх

2022 онд ОНХС-н иргэдээс авсан саналын дагуу хийгдсэн ажлийн тайланг танилцуулах

Аха тэмцээн зохин байгуулах

**Сумын онцгой комисс:**

7-р сарын 11-ны өдөр орсон их хэмжээний борооны улмаас усанд боогдож машин суусан байсан 4 иргэнийг сумын онцгой комисс эмнэлгийн дарга Э.Баасангарав, цэцэрлэгийн жижүүр Б.Даваасүрэн, здтг-н жолооч Ганзориг, эмнэлгийн жолооч Д.Зоригт, талын илчийн селесер Т.Гомбо нарын бүрэлдэхүүнтэй комисс фургон маркийн 24-79 убз улсын дугаартай авто машинаар шуурхай арга хэмжээ зохион байгуулан татаж гаргасан мөн 1 иргэн гэмтэл авч эмнэлэг явах замдаа машин нь сууж явах аргагүй болсон дуудлага дээр ажиллаж машиныг нь гаргаж анхны тусламжийг цаг алдалгүй үзүүлж аймгийн нэгдсэн эмнэлэг рүү явуулж ажилласан байна.

Машин татах явцад фургон маркийн 24-79 убз улсын дугаартай авто машин духны гинж тасарч эвдэрсэн тул здтг-н Toyota fielder маркийн 79-19гса улсын дугаартай машинаар ажилласан.

**Орон нутаг хөгжил сан**

2023 ОНХС-н ажил - Сургуулийн спорт заалыг ариун цэвэрийн өрөөтэй болгох .

27.000 сая төгрөгний тендерт шалгарсан Талын илч ОНӨААТҮГазар ажилаа хийж гүйцэтгэж 70% гүйцэтгэлтэй явж байна.

ОНХСангийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн тоглоомын талбай эд хөрөнгийг засварлах ажилыг 5.500 төгрөгөөр хийж гүйцэтгэж байна .

**Иргэдийн ая тухтай амьдрах орчинг бүрдүүлэх :**



Баяр наадмыг угтсан иргэдийн нийтийн их цэвэрлэгээг хийж гүйцэтгэлээ.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:**

**Амбулаторийн үйлчилгээ:**

- Нийт үзлэг-68
- Амбулаторийн үзлэг-64 Үүнээс:
- Яаралтай түргэн тусламж-29 хүн
- Идэвхитэй хяналт-3 хүн
- Өдрийн эмчилгээ-0 хүн
- Хэвтэн эмчлүүлсэн- 6 хүн
- Өдрийн эмчилгээ-1
- 

**Түргэн тусламжийн дуудлагын төрөл, тоо хэмжээ:**

- Нийт дуудлага -13
- Алсын дуудлага -7
- Төвийн дуудлага-9
- Том хүн -17
- Хүүхэд-8
- Осол гэмтэл-1

**Стационарийн үйл ажиллагаа:**

- Хэвтэн эмчлүүлэгчид нийт-6
- Дотор -6
- Хүүхэд -0
- Халдварт-0
- **Лабораторийн үзлэгийн тоо: 10 /давхардсан тоо/**
- -Цусны ерөнхий шинжилгээ
- -Биохимийн шинжилгээ
- -Шээсний шинжилгээ

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР:**

**Өвөлжилтйн бэлтгэл ажлыг хангах :**

Сумын засаг даргийн захирамжаар өвөлжилтийн бэлтгэл ажлийг хангах ажлийн хэсэг гарж

Иргэд болон байгууллага албан газруудад өвөлжилтйн бэлтгэл ажлийг хангах төлөвлөгөөг ирүүлэхээр ажиллаж байна. Хадланд гарах иргэдийг хадлан бэлтгэж боломж бололцоог олгох үүднээс зарим нэг сумдуудтай гэрээ байгуулахаар ажиллаж байна.

**-Малын өвчний байдал, тайван эсэх:**

Одоогоор малын өвчлөл гараагүй тайван байна.

**Цаг агаарын аюулт үзэгдлийн мэдээ дамжуулж байгаа мэдээлэл:**

Цаг агаарын мэдээ болон аюулт үзэгдлийн мэдээг Баянтал ХААТ дундын групп, багуудын Засаг дарга нар болон багийн цахим хаягаар мэдээллийг тогтмол хүргэж хэвшсэн. Мөн WHAT 3 WORDS аппикэйшний талаар малчдад мэдээлэл хүргэсэн.

ТАЙЛАН ГАРГАСАН

АБХЭРХЛЭГЧ

Н.МӨНГӨНЦЭЦЭГ